

ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь газрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа болон мэдээлэл солилцооны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.1-2.1.4-т заасан систем (цаашид "мэдээллийн систем" гэх)-ээр дамжуулан газар зохион байгуулалт, газрын кадастр, газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын мониторингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээртэй холбоотой мэдээллийг бүрдүүлэх, бүртгэх, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг энэхүү журмын дагуу зохион байгуулна.

1.3.Энэхүү журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид "эрхлэгч байгууллага" гэх), аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал, газартай холбоотой үйл ажиллагаа эрхлэх төрийн захиргааны бусад байгууллагууд (цаашид “Газрын алба” гэх) энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.4.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал (цаашид “албан хаагч” гэх) нь мэдээллийн системд мэдээллийг бүрдүүлэх, бүртгэх, баяжуулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг хариуцна.

Хоёр. Системийн эрхийн зохицуулалт

2.1.Мэдээллийн системд хандах эрхийн зохицуулалт, хандах эрхийн түвшин нь Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.2-3.1.4-т хамаарна.

Гурав. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн системийн үйл ажиллагаа

3.1.Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем нь газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллээр иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх, хилийн цэс, тусгай хэрэгцээ, хамгаалалтын бүс, зурвас газрын мэдээллийн санг хөтлөх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.Систем нь төлөвлөлтийн ерөнхий бүс, дэд бүс, төлөвлөлтийн арга хэмжээ, хилийн цэс, тусгай хэрэгцээний газар, хамгаалалтын бүс зурвас газрын мэдээллүүдийг агуулсан давхаргуудаас бүрдэнэ.

3.3.Төлөвлөлтийн ерөнхий бүсэд хамаарах дэд бүсүүд, дэд бүсүүдэд зөвшөөрөх болон хориглох арга хэмжээнүүдийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалд нийцүүлэн тохируулна.

3.4.Газрын тухай хууль тогтоомж болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн аргачлалд нийцүүлэн төлөвлөлтийн арга хэмжээний төрлийг тодорхойлж, цахим системд бүртгэнэ.

3.5.Төлөвлөлтийн арга хэмжээний төрөл нь төлөвлөлтийн бүс, арга хэмжээний төрөл, газрын эрхийн төрөл, батлагдсан албан ёсны хаяг эсхүл газрын нэр, газрын нэгдмэл сангийн ангилал, зориулалтын талаарх өгөгдлүүдийг заавал тусгасан байна.

3.6.Системд төлөвлөлтийн нэгж талбарыг төлөвлөхдөө гудамж, зам, талбайн нэр, орц, гарц, гудамжны эхлэл, төгсгөлийг төлөвлөж бүртгэсэн байна.

3.7.Төлөвлөлтийн нэгж талбарыг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэгдсэн тусгай хэрэгцээний газар, хамгаалалтын бүс, зурвас газар, ашигт малтмалын ашиглалтын талбай, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон дээд шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний давхаргуудтай давхцал, зөрчлийн мэдээллийг шалгана.

3.8.Шалгалтын явцад илэрсэн орон зайн мэдээллийн зөрчил, топологийн алдааг засварлаж, шаардлага хангасан мэдээллийг цахим системд оруулах бөгөөд төлөвлөгөөний нэгж талбар бүр дараалсан давтагдашгүй дугаар авч системд бүртгэгдэнэ.

3.9.Системийн хавсралт хэсэгт төлөвлөгөөний үе шатны тайлан, төлөвлөгөөний төсөлд өгсөн дүгнэлт, төлөвлөгөөг батлах, засвар өөрчлөлт оруулахтай холбоотой эрх бүхий байгууллагын шийдвэр болон бусад холбогдох материалуудыг заавал оруулна.

3.10.Системд төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тодорхой үе шат, төлөвийн дагуу хэрэгжих бөгөөд үе шат бүр нь холбогдох тохиргоотой байна.

3.11.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж дууссаны дараа хяналт хийх эрх бүхий байгууллага хянаж, шаардлага хангасан тохиолдолд цахим системийн хяналтын төлөвт шилжүүлэн, холбогдох дүгнэлт гаргуулахаар илгээнэ.

3.12.Хяналтын төлөвт шилжүүлсэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан дүгнэлт гаргана.

3.13.Баталгаажсан дүгнэлтийг үндэслэн төлөвлөгөөг батлах эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлнэ. Хэлэлцүүлгээс гарсан шийдвэр, хурлын тэмдэглэлийг үндэслэн шаардлагатай засвар, өөрчлөлтийг 14 хоногийн дотор хийж, төлөвлөгөөний төслийг баталгаажуулах төлөвт шилжүүлнэ.

3.14.Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг батлах эрх бүхий байгууллагын шийдвэрт системээс олгосон төлөвлөлтийн нэгж талбарын давтагдашгүй дугаар болон гудамжны нэрийг заавал тусгасан байна.

3.15.Төлөвлөгөөний төсөл батлагдсан төлөвт шилжсэн даруйд уг төлөвлөгөөнд засвар, өөрчлөлт оруулах эрхийг цахим системээр автоматаар хаана.

3.16.Эрх бүхий байгууллагаас батлагдсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөлтийн нэгж талбарын эрхийн төрөл, арга хэмжээний төрөл, бүсчлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд өөрчлөлтийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон нотлох баримтыг цахим системийн хавсралт хэсэгт байршуулж, төлөвлөгөөг боловсруулах эрх бүхий байгууллага холбогдох өөрчлөлтийг хийнэ.

3.17.Энэ журмын 3.16-д зааснаас бусад тохиолдолд газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот төлөвлөлтийн баримт бичгийн бүс, арга хэмжээний төрөл, зориулалт, байршил, хэмжээнд засвар, өөрчлөлт оруулах тохиолдолд төлөвлөгөөг батлах эрх бүхий байгууллагын шийдвэр, батлагдсан баримт бичгийг үндэслэнэ.

3.18.Төлөвлөгөөний төслийн бүс, арга хэмжээний төрөл, зориулалт, байршил, хэмжээ өөрчлөх асуудалд тухайн төлөвлөгөөнд хяналт тавих эрх бүхий байгууллага хяналт тавина.

3.19.Батлагдсан төлөвлөгөөний төлөвлөлтийн нэгж талбарын талбайн хэмжээг багасгах, эсхүл батлагдсан талбайн хэмжээнд нийцүүлэн хэлбэр, хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд өөрчлөлтийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон нотлох баримтыг цахим системийн хавсралт хэсэгт байршуулж, төлөвлөгөөг хянах эрх бүхий байгууллага хянаж, төлөвлөгөөг боловсруулах эрх бүхий байгууллага холбогдох өөрчлөлтийг хийнэ.

3.20.Батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөлтийн нэгж талбарын талбайн хэмжээг нэмэх, байршил өөрчлөх тохиолдолд төлөвлөгөөг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төлөвлөгөөг боловсруулах эрх бүхий байгууллага холбогдох өөрчлөлтийг хийж гүйцэтгэнэ.

3.21.Батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөлтийн нэгж талбар нь төлөвлөгөө боловсруулсан тухайн онд хүчинтэй байна. Төлөвлөгөөний хэрэгжих хугацаанд засвар, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд төлөвлөгөөг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төлөвлөгөөг боловсруулах эрх бүхий байгууллага холбогдох өөрчлөлтийг хийнэ.

3.22.Батлагдсан аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний бүсчлэл болон нэгж талбарын төлөвт засвар, өөрчлөлт оруулах тохиолдолд төлөвлөгөөг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төлөвлөгөөг хянах эрх бүхий байгууллага холбогдох өөрчлөлтийг хийнэ.

Дөрөв. Газрын кадастрын системийн үйл ажиллагаа

4.1.Газрын тухай хууль, Кадастр зураглал ба газрын кадастрын тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд заасны дагуу газрын кадастрын систем нь газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хил зааг, зураглал, талбай, эрхийн төрөл, тэдгээрийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн үндсэн болон шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх, кадастрын дэс дараалсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.Мэдээллийн системд иргэн, хуулийн этгээдийг дараах байдлаар бүртгэнэ:

4.2.1.Төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэний бүртгэлийн дугаараар иргэний мэдээллийг татан авч мэдээллийг хадгална.

4.2.2.Төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн сангаас байгууллагын регистрийн дугаараар хуулийн этгээдийн мэдээллийг татан авч мэдээллийг хадгална.

4.2.3.Төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан татварын мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн дугаарыг татан авч мэдээллийг хадгална.

4.2.4.Хэрэв иргэн, хуулийн этгээдийн татвар төлөгчийн дугаар бүртгэлгүй тохиолдолд тухайн харьяалал бүхий Татварын албанд хандаж, бүртгэлийг үүсгүүлэх талаар хүсэлт гаргагчид мэдээлнэ.

4.3.Иргэн, хуулийн этгээд (цаашид "хүсэлт гаргагч" гэх)-ийн газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хүсэлтийг мэдээллийн систем (www.egazar.gov.mn)-ийн иргэд, олон нийтэд зориулсан хэсэгт, эсхүл төрийн үйлчилгээний нэгдсэн цахим систем (e-mongolia), газрын харилцааны үйлчилгээний цахим машин (КИОСК) ашиглан цахимаар хүлээн авч, холбогдох хуульд заасан хугацаанд багтаан шийдвэрлэнэ.

4.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хүсэлт гаргах үед хүсэлтийн маягт, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдүүлгийн маягт болон иргэний мэдээллийг цахим системд автоматаар үүсгэж хүсэлтэд хавсаргана.

4.5.Хариуцсан мэргэжилтэн мэдээллийн системээр дамжуулан хүлээн авсан цахим хүсэлт (цаашид "хүсэлт" гэх)-ийг шийдвэрлэхдээ Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 1.8-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.6.Энэ журмын 4.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлсэний дараа мэдээллийн системд хүсэлтийг төлөвийг өөрчилж өргөдөл үүсгэн "Хүсэлт хүлээн авсан тухай тодорхойлолт"-ыг цахим системээр хүргүүлнэ.

4.7.Хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд хууль зүйн үндэслэл бүхий тодорхой шалтгаан, нөхцөлийг дурдан, буцаасан төлөвт шилжүүлж "Хариу өгөх мэдэгдэл"-ийг хүсэлт гаргагчид цахим системээр хүргүүлнэ.

4.8.Шинээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох хүсэлтийг шийдвэрлэхдээ энэ журмын 3.13-т заасан баталгаажсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгж талбараас холбож шийдвэрлэнэ.

4.9.Мэдээллийн системд бүртгэгдсэн нэгж талбарын кадастрын зураглалын өөрчлөлтийг хийж гүйцэтгэхдээ дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

4.9.1. Хүсэлт гаргагчийн хүсэлтэд хавсаргагдсан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр үйлдүүлсэн зургийг боловсруулан, газрын кадастрын мэдээллийн сангийн ажлын нэгж талбар хэсэгт оруулна.

4.9.2.Ажлын нэгж талбарын топологи алдааг шалгаж, холбогдох мэдээллийг засварлаж хадгалснаар системээс нэгж талбарын түр дугаар олгогдоно.

4.9.3.Кадастрын зураглалын өөрчлөлт бүрэн дууссанаар тухайн нэгж талбаруудыг мэдээллийн системд бүртгэгдсэн өргөдөлтэй холбоно.

4.10.Энэ журмын 4.8, 4.9-д заасан нэгж талбартай холбогдсон өргөдлийн явцыг "шийдвэрийн төсөлд илгээх" төлөвт шилжүүлэн газрын эрх олгох шийдвэрийн төслийг үүсгэнэ.

4.11.Газрын эрх олгосон шийдвэр гарсны дараагаар шийдвэрийн мэдээллийг системд бүртгэж, шийдвэрийн цаасан эх хувийн цахим хуулбарыг хавсаргана.

4.12.Эрх бүхий этгээдийн шийдвэр мэдээллийн системд бүртгэгдсэн тохиолдолд Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 1.13-т заасан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаа болон энэ журмын 5.1-т заасан газрын төлбөр, татвар тооцох, ногдуулах, нэхэмжлэл үүсгэх үйл ажиллагааг цахим систем автоматаар гүйцэтгэнэ.

4.13.Өргөдөл нь газар өмчлөх эрхийн төрөлтэй бол газар өмчлөлийн бүртгэлийг системд бүртгэж агентлагийн даргын тушаалаар батлагдсан “Иргэнд өмчлүүлж кадастр хийх журам”-ын 9.1-т тусгагдсан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

4.14.Үл хөдлөх эд хөрөнгө, барилга байгууламжийн мэдээллийг бүртгүүлэх хүсэлтийг цахим системээр дамжуулан хүлээн авна.

4.15.Хүсэлт гаргагч нь үл хөдлөх эд хөрөнгө, барилга байгууламжийн хил зааг, солбицлын утгыг тусгасан зургийг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр үйлдүүлж, хүсэлтийн маягтын хамт цахим системд ирүүлнэ.

4.16.Газрын алба нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 1 өдөрт багтаан хүсэлтэд хавсаргасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгө, барилга байгууламжийн хил зааг, солбицлын утгыг тусгасан зургийг үндэслэн мэдээллийн системд бүртгэнэ.

4.17.Мэдээллийн системд бүртгэгдсэн газар болон үл хөдлөх эд хөрөнгийн мэдээлэл, түүнд холбогдох баримт бичгийн цахим хавсралтыг эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр өөрчлөх, засварлах, устгах, түүнчлэн эрх зүйн харилцаа үүсээгүй нэгж талбарын мэдээллийг мэдээллийн системд бүртгэхийг хориглоно.

Тав. Газрын төлбөр, татвар тооцох, ногдуулалт, нэхэмжлэл үүсгэх үйл ажиллагаа

5.1.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан нэгж, Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд Газрын төлбөр, татварын цахим системийг ашиглан газрын төлбөр, татвар тооцох, ногдуулалт, нэхэмжлэл үүсгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.2.Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй нийт нэгж талбар тус бүрт газрын төлбөрийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу тооцно.

5.3.Тухайн нэгж талбар дээр хэд хэдэн иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа бол газрын төлбөрийг тус нэгж талбарын хууль ёсны дагуу эзэмшигч, ашиглагчид ногдуулна.

5.4.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан заавраар батлагдсан уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ашиглалт явуулж буй хэсгийг Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу 2 дахин өсгөж тооцно.

5.5.Энэ журмын 5.4-т заасан хэсгээс бусад талбайд буюу уурхайн ажилчдын амрах байр, баяжуулах болон боловсруулах үйлдвэр, оффис, машин механизмын засварын газар, граш болон олборлолт хийгдээгүй нөөц газар зэргийн газрын төлбөрийг хот, тосгон, бусад суурины газрын хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэлийн зориулалттай газрын суурь үнийн тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан хувь хэмжээгээр тооцно.

5.6.Эрхийн улсын бүртгэлд Газар эзэмших, ашиглах эрх шинээр бүртгэгдсэн даруйд газрын төлбөрийг ногдуулж, нэхэмжлэлийг 10 хоногийн дотор үүсгэнэ.

5.7.Дараах тохиолдолд газрын төлбөр, татварын нэхэмжлэлийг цуцлана.

5.7.1.Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч өөрийн хүсэлтээр газрын эрхээсээ татгалзаж, дуусгавар болсон тохиолдолд тухайн жилийн үлдсэн хугацааны газрын төлбөрийн нэхэмжлэлийг;

5.7.2.Эрх бүхий этгээдийн шийдвэрээр газрын зориулалт, талбай, байршилд өөрчлөлт оруулах шийдвэр гарсан өдрөөс хойшхи газрын төлбөрийн нэхэмжлэлийг;

5.7.3.Хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан тохиолдолд тухай шийдвэрийг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойшхи газрын төлбөрийн нэхэмжлэлийг;

5.7.4.Шүүхийн шийдвэрээр;

5.7.5.Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн шийдвэрээр;

5.7.6.Мэдээллийн санд нэхэмжлэл давхардуулж үүсгэсэн тохиолдолд.

5.8.Газрын төлбөр, татварын нэхэмжлэлийг журмын 5.7-д зааснаас бусад тохиолдолд цуцлахыг хориглоно.

Зургаа. Газрын мониторингийн үйл ажиллагаа

6.1.Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5-д заасны дагуу газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгаанд хамруулна.

6.2.Газрын мониторингийн системд газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.2.1.Газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч нь газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мэдэгдэх хуудсыг мэдээллийн систем (www.egazag.gov.mn)-ийн иргэд, олон нийтэд зориулсан хэсэгт, эсхүл газрын харилцааны үйлчилгээний цахим машин (КИОСК) ашиглан авна.

6.2.2.Газрын мониторингийн системд эрх бүхий мэргэжлийн байгууллага нь мэдэгдэх хуудсыг үндэслэн хянан баталгааны судалгааг хийж, тайланг боловсруулан илгээнэ.

6.2.3.Агентлагийн ерөнхий шинжээч, аймаг, нийслэлийн байнгын шинжээч тайланг хянаж, дүгнэлтийг баталгаажуулна.

6.3.Газрын мониторингийн системд газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

6.3.1.Тухайн аймаг, нийслэлийн мониторингийн мэргэжилтэн төслийн хилийг системд зураглаж, төслийн дугаарыг үүсгэнэ.

6.3.2.Тухайн ажлыг гүйцэтгэхээр шалгарсан эрх бүхий мэргэжлийн байгууллага төслийн дугаарт үндэслэн хянан баталгааны судалгааг хийж, тайланг боловсруулан Газрын мониторингийн системд илгээнэ.

6.3.3.Агентлагийн ерөнхий шинжээч, аймаг, нийслэлийн байнгын шинжээч тайланг хянаж, баталгаажуулан үр дүнг архивт хүлээн авч, акт дүгнэлт үйлдэнэ.

6.3.4.Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д заасны дагуу анх удаа иргэн аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил ашиглалтад олгож байгаа газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг төлөвлөгөөт хянан баталгааны үр дүнгээр гаргаж өгнө.

Долоо. Мэдээлэл солилцох үйл ажиллагааны

7.1.Мэдээлэл солилцох үйл ажиллагаа дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

7.2.Дундын мэдээллийн сангийн холболт

7.2.1.Дундын мэдээллийн сангийн удирдлагын систем нь газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн дэд системүүдийн өгөгдлийн сантай холбогдсон байна.

7.2.2.Дундын мэдээллийн сан нь төрийн болон бусад байгууллагын мэдээллийн сантай холбогдон өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.

7.2.3.Дундын мэдээллийн сангийн холболтыг өгөгдөл солилцооны техникийн стандарт, аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

7.3.Мэдээлэл хүлээн авах, хадгалах, боловсруулах, түгээх, шинэчлэх

7.3.1.Дундын мэдээллийн сан нь өгөгдөл, мэдээллийг хүлээн авах, хадгалах, боловсруулах, түгээх болон шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.3.2.Дундын мэдээллийн санд хүлээн авсан өгөгдөл, мэдээллийг тогтоосон бүтэц, формат, кодчлолын дагуу боловсруулж, хадгална.

7.3.3.Дундын мэдээллийн санд бүртгэгдсэн өгөгдөл, мэдээллийг тухайн мэдээллийн хэрэглээний зориулалт, ашиглалтаас хамаарч эрх бүхий хэрэглэгч болон холбогдох байгууллагад түгээнэ.

7.3.4.Өөрчлөлт орсон мэдээллийг тухай бүр сонсох байдлаар шинэчлэнэ.

7.4.Нээлттэй өгөгдөл, мэдээлэл түгээх

7.4.1.Дундын мэдээллийн санд бүртгэгдсэн нээлттэй өгөгдөл, мэдээллийг Геопортал болон Төрийн мэдээлэл солилцооны системээр иргэн, хуулийн этгээдэд түгээнэ.

7.4.2.Нээлттэй өгөгдөл, мэдээллийг түгээхдээ Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

7.5.Мэдээлэл солилцох үйл ажиллагаа

7.5.1.Дундын мэдээллийн сан нь төрийн болон бусад байгууллагын мэдээллийн сантай төрийн мэдээлэл солилцооны систем, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан өгөгдөл, мэдээлэл солилцоно.

7.5.2.Мэдээлэл солилцох үйл ажиллагааг Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам болон мэдээллийн аюулгүй байдлын холбогдох шаардлагын дагуу хэрэгжүүлнэ.

7.6.Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал

7.6.1.Дундын мэдээллийн санд хадгалагдаж буй болон өгөгдөл солилцох үйл ажиллагааны явцад үүсэх мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, бүрэн бүтэн байдлыг бүрэн хангаж ажиллана.

Найм. Мэдээллийн системийн хэрэглэгч

8.1.Иргэн, хуулийн этгээд нь мэдээллийн системд төрийн танилт, нэвтрэлтийн ДАН системийг ашиглан баталгаажуулалт хийж (нэг удаагийн код, банкны эрх, тоон гарын үсэг) нэвтэрнэ.

8.2.Албан хаагч нь албан үүргээ хэрэгжүүлэх зорилгоор байгууллагаас олгосон хандалтын хэрэглэгчийн эрхийн дагуу системд нэвтэрч, үйл ажиллагаагаа явуулна.

8.3. Системийн хэрэглэгч нь системд нэвтрэх нууц үгийг 3 сар тутамд шинэчилнэ. Нууц үг нь том, жижиг үсэг, тоо болон тусгай тэмдэгт агуулсан, түгээмэл хэрэглэгддэггүй, 8-оос доошгүй тэмдэгт байна.

8.4. Системд засвар, өөрчлөлт хийсэн хэрэглэгчийн мэдээлэл, хугацаа, өөрчлөлтийн түүхийг бүртгэж, хадгална.

Ес. Хүлээлгэх хариуцлага

9.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, хүн, хуулийн этгээд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

---oOo---